“Нааш-Ир” холбооны дүрэм

Товч тодорхой бичихийн тулд энэхүү дүрэмд хуучнаар хүйс заасан үгсийг эр хүйсээр нь бичсэн болно. Хүйсээр ялгагддаг үгс нь аль ч хүйсийн хүнийг төлөөлнө.

Монголын орчуулгын “Ямуха” албанд орчуулж баталгаажуулав.
Утас/факс: +976-11-311236

1. **Нэр , байршил**
   `Нааш-Ир` холбоо нь Швецарийн иргэний хуулийн 60-р зүйлийн дагуу хязгааргүй хугацаагаар Цюрих хотод байршилтай байна.

2. **Зорилго**
   Тус холбоо нь
   - Шашин ба улс төрөөс хамааралгүй төвийг сахисан байгууллага юм.
   - Монголчууд болон тэдний хамаатан саднуудыг Швецарид нийгэмшихэд тусалдаг
   - Туршлага солилцох, холбоо сүлжээ байгуулахад дэмжлэг үзүүлж эх хэл дээр нь сургалт, зөвлөгөө өгдөг
   - Төрөл бүрийн сургалтын болон бусад үйл ажиллагаа зохион байгуулдаг
   - Монгол хэл соёл, амьдрах ухааныг хөхүүлэн дэмждэг
   - Монгол хэл, соёлын хичээл заадаг
   - Монгол соёл ба Монголын талаар олон нийтэд мэдээлэлдэг
   - Хүүхдүүдэд Монгол хэлний мэдлэгээ тоглонгоо сайжруулах боломж олгодог

3. **Санхүүжилт**
   Холбооны зорилгыг биелүүлэх санхүүжилтийг гишүүдийн хураамж, холбооны хөрөнгийн орлого, олон нийтийн тусламж, хандив, бэлэг ба сургалт үйл ажиллагааны орлогоос бүрдүүлнэ.

5. **Гишүүнчлэл**

Холбооны зорилгыг биелүүлэх сонирхолтой энгийн ба хуулийн этгээдүүд гишүүн болж болно.

Гишүүн элсүүлэх эсэхийг удирдах зөвлөл шийднэ. Гишүүнчлэл дараах янзаар ялгаатай байна:

- Идэвхитэй гишүүд нь энгийн хувь хүмүүс байна. Тэд төсөвт заагдсан хэмжээний гишүүнчлэлийн хураамжаа төлөх үүрэгтэй. Үүгээр тэд санал өгөх ба сонгуульд саналаа өгөх бүрэн эрхтэйгээс гадна холбооноос зохион байгуулж буй үйл ажиллагаанд хөнгөлөлт эдлэнэ.
- Сонирхогч гишүүд нь холбооны үйл ажиллагаанд сонирхолтой боловч арга хэмжээнд оролцдоггүй эсвэл хаяа оролцдог энгийн эсвэл хуулийн этгээд байж болно.

6. **Гишүүнчлэлээс хасах**

Гишүүнчлэлээс гарахдаа холбооны жил дуусахаас 4 долоо хоногийн өмнө удирдах зөвлөлд бичгээр тайлбарлаж гарна. Түүнээс хойш дараах жилдээ

гишүүнчлэлээ хүчинтэй болгож болохгүй. Мөн нас барсан тохиолдолд эсвэл хасагдах үед гишүүнчлэлгүй болно. Хэрэв гишүүд холбооны сонирхолд хор уршиг учруулах эсвэл холбооны амьдралд муугаар нөлөөлвөл удирдах зөвлөл тэднийг Холбооноос гарч буй гишүүнчлэлээс хасах эрхтэй. Холбооноос гарч буй гишүүд холбооны эд хөрөнгийг захирах эрхгүй ба ямар нэгэн хураамж төлбөрийн нөхөн олголт авах эрхгүй. Гэсэн хэдий ч тэд дараачийн ерөнхий хуралд давж заалдахаар оролцох эрхтэй.

7. Холбооны байгууллагууд

Холбооны байгууллага гэж дараахыг хэлнэ:

- Ерөнхий хурал
- Удирдах зөвлөл
- Хяналтын алба

8. Ерөнхий хурал

Ерөнхий хурал нь холбооны хамгийн дээд байгууллага. Энгийн ерөнхий хурал жилд нэг удаа ба Монголын зуны амралт эхлэхээс өмнө болно.

Удирдах зөвлөл бичгээр багадаа 10 хоногийн өмнө хэлэлцэх асуудлын хамт гишүүдэд урилга илгээнэ. Ингэхдээ шуудан ба электрон шууданг аль альнийг нь бичгээр харилцсан гэж үзнэ. Энгийн бус удирдах зөвлөл зарлаж болно. Гишүүдийн гуравны нэг нь бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд мөн энгийн бус хурал хийгдэнэ.

Ерөнхий хурлаар альваа зүйлийг гишүүдийн хагасын оролцоотойгоор батлана.

Ерөнхий хурлаар ялангуяа дараах асуудлуудыг шийдвэрлэнэ:

- Сүүлчийн ерөнхий хурлын протоколлыг зөвшөөрөх
- Удирдах зөвлөлийн сонгууль хийх
- Хяналтын алба сонгох
- Удирдах зөвлөлийн жилийн тайланг хүлээж авах батлах
- Хяналтын хэлтсийн тайлан ба жилийн санхүүгийн тайланг хүлээн батлах
- Төсвийг зөвшөөрөх ирсэн гишүүдийн гуравна нэгийн саналаар
- Гишүүнчлэлийн хураамжийг тогтоох
- Дүрэм журам өөрчлөх \хүрэлцэн\
- Удирдах зөвлөлийн эсвэл гишүүдийн санал хүсэлтийг шийдвэрлэх
- Холбоог татан буулгах эсэхийг шийдвэрлэх

Хурлаар яригдах санал хүсэлтүүдийг ерөнхий хурал болохоос ядаж 2 долоо хоногын өмнө удирдах зөвлөлд ирүүлсэн байх ёстой, эс бөгөөс хэлэлцүүлэх эрхгүй болно.

Ерөнхий хуралд гишүүн бүр санал өгөх эрхтэй. Дүрэм журамд тусгайлан заагаагүй бол хүрэлцэн ирсэн саналын дийлэнх нь ерөнхий хуралд шийдвэр гаргана.
Санал тэнцүү хуваагдсан тохиолдолд ерөнхийлөгч нь эцсийн шийдвэр гаргах эрхтэй болно.
Ерөнхий хурлын талаар актуар протоколл хөтлөж хурлаас хойш гурван долоо хоногын дотор бүх гишүүдэд бичгээр хүргэсэн байх.

9. Удирдах зөвлөл

Удирдах зөвлөл нь – жил тутам сонгогдох багадаа 3 хүнээс бүрдсэн байна. Нөхөн сонгууль хийх боломжтой. Сонгуулийг ээлжлэн явуулна: Нэг жил нь ерөнхийлөгч ба актуарыг сонгох бол дараах жил нь дэд ерөнхийлөгч касс няраваа сонгоно.
Удирдах зөвлөл байнгын үйл ажиллагааг удирдаж, холбоог гадагш нь төлөөлнө. Гэрээ байгуулахад тэр дангаараа төлөөлөх эрхтэй. Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай үед удирдах зөвлөл хурал зөвлөгөөнд сууна. Удирдах зөвлөлийн гишүүн бүр хуралдуулах эрхтэйв Удирдах зөвлөлийн хурлын талаар багадаа гарсан шийдвэрүүдийг тусгасан протоколл хөтөлж УЗ-д 14 хоногийн дотор танилцуулсан байна.
Гарын үсэг зурах эрх зүй дараах байдлаар зохицуулагдана:
Үйл ажиллагааны харилцах бичиг баримтууд: дан холбооны ерөнхийлөгчийн гарын үсэг
Гэрээ ба санхүүгийн үйлдлүүд, санхүүжилт ба онц чухал харилцаа холбоо: Холбооны ерөнхийлөгч өөр нэгэн УЗ-ийн гишүүнтэй хамт хоёул гарын үсэг зурна. Ерөнхийлөгчийг байхгүй үед дэд ерөнхийлөгч орлоно. Санхүүгийн үүрэг хариуцлагатай бол касс, нярав нэмэлт гарын үсэг зурна.

10. Хяналтын алба

Хяналтын алба нь 1 эсвэл 2 хүнээс бүрдэх бөгөөд касс орох эрхгүй. Мөн гадны аудитын байгууллагаар хяналт хийлгэсэн ч болно. Хяналтын албыг 2 жил тутам сонгох ба нөхөн сонгууль хийж болно.

11. Холбооны жил

Холбоон жил нь Монгол улсын сургуулийн шинэ жилтэй зэрэг эхлэнэ.

12. Гишүүнчлэлийн хураамж ба хариуцлага

Холбооны альваа өрийг зөвхөн холбооны хөрөнгө данс хариуцна. Гишүүд хувиараа хариуцах боломжгүй. Гишүүд жилийн хураамжын төлбөрөө л хариуна.

Гишүүнчлэлийн хураамжыг ганц биеээр эсвэл гэр бүлээр төлж болно. Гэр бүлийн гишүүнчлэлийн хураамж төлөгдсөн бол тухайн гэр бүлийн насанд хүрсэн гишүүн холбоонд орсноор бүрэн сонгуулийн эрхтэй бие даасан холбооны гишүүн болно. Гэр бүл гэж нэг том хүн эсвэл эцэг эх хоёр насанд хүрээгүй хүүхдүүдийн хамт орох эрхтэй.

13. Холбоог татан буулгах

Холбоог татан буулгахад удирдах зөвлөл холбооны эд хөрөнгийг адил эсвэл төстэй байгууллагад шилжүүлнэ. Холбоог татан буулгахад холбооны гишүүдийн гуравны хоёрын санал шаардлагатай болно.

14. Дүрэм хүчин төгөлдөр болох

Энэхүү дүрэм нь 2014 оны 9-р сарын 24-ний хурлаар хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд шууд хүчинтэй болсон. Үүгээр альваа өмнө гаргасан дүрэм, шийдвэр, нэмэлтүүд бүгд хүчингүйд тооцогдоно.

Хот, огноо Цюрих хот, 2014.10.09